

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 9 дүгээр сарын 09
Тендер шалгаруулалтын нэр: Тэсрэх материалын агуулах
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112458

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр Тэсрэх материалын агуулахын зураг төсөв, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50,000.00 /тавин мянган/ төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 онуудын гүйцэтгэсэн борлуулалтын дундаж хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50 %-аас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 50 сая төгрөгөөс багагүй байна.

Аудитын дүгнэлт ирүүлэх жилийн тоо: 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эх хувиар эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар хувь ирүүлнэ.

Тусгай зөвшөөрөл: Уул уурхайн зураг төсөл боловсруулах

Туршлага: Тэсрэх материалын агуулах, уул уурхайн үйлдвэрийн зураг, төсөл боловсруулах, барьж байгуулсан 2-аас доошгүй жилийн туршлагатай байх,

Тендерийн хамт 1 000 000.00 төгрөгийн дүнтэй цахим системээр тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2021 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 10:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 10:05 цагт цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Зөвшөөрөхгүй.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс авч болох ба тендерийн тодруулгыг Захиалагч www.tender.gov.mn хаягаар цахим хэлбэрээр хүлээн авна.

“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ